

Гадасны аудитын хороо

Энэ баримтанд гадасны аудитын хорооны зорилго, зохион байгуулалт, үүрэг хариуцлагыг тоймлосон болно.



Тайлбар: Энэ баримтан дахь гадасны ерөнхийлөгч, гадасны аудитор болон гадасны бичиг хэргийн ажилтан гэсэн нэр томъёонууд дүүрэг, номлолын адил дуудлагуудад мөн хамаатай болно. Гадасны аудитын хороо гэдэг нэр томъёо дүүрэг, номлолын аудитын хороодод мөн хамаатай. Бичиг хэргийн ажилтан гэсэн нэр томъёо нь бичиг хэргийн ажилтан болон санхүү хариуцсан туслах бичиг хэргийн ажилтнуудын аль алиныг хэлж байгаа болно. Нэгжийн удирдагч гэж бишоп болон салбар, гадас, дүүргийн ерөнхийлөгчдийг хэлж байгаа болно. Гадас гэдэгт дүүргийг мөн хамааруулан ойлгож болно. Тойрог гэдэгт салбарыг мөн хамааруулан ойлгож болно.

1. Зорилго

Гадасны ерөнхийлөгч Сүмийн бүх мөнгөн хөрөнгө Сүмийн санхүүгийн зааврын дагуу зөв захиран зарцуулагдаж, бүртгэл тооцоо нь хийгдэж байгаа эсэхэд анхаарал тавина (*Гарын авлага 1: Гадасны ерөнхийлөгч ба бишоп* [2010], 14.6-г үзнэ үү). Тэрээр мөн нэгжийн удирдлага болон бичиг хэргийн ажилтнууд санхүүгийн холбогдолтой үүрэг хариуцлагаа мэдэж авч, Сүмийн санхүүгийн дүрэм журмыг дагадаг байхад анхаарна (*Гарын авлага 1, 14.2.1-ийг үзнэ үү*). Тэрээр энэ үүргээ биелүүлэхэд туслуулахаар гадасны аудитын хороог зохион байгуулдаг. Гадасны аудитын хороо нь гадасны санхүүгийн эрсдлүүдийг, ялангуяа Сүмийн хөрөнгийг буруугаар зарцуулах эрсдлийг илрүүлж, дүгнэж, мөн арилгах арга хэмжээг авдаг. Гадасны аудитын хороо нь нэгжийн удирдлага болон бичиг хэргийн ажилтнуудыг Сүмийн санхүүгийн дүрэм журмыг дагадаг байхад анхаарна.

Тэргүүн Зөвлөл ариун сан хөмрөгийг хамгаалж, зохистой ашиглахын тулд мөн санваарын

удирдагч, бичиг хэргийн ажилтнуудыг хүчирхэгжүүлэхийн тулд бүсийн аудитын хороодыг зохион байгуулсан. Гадасны аудитын хороо нь үүрэг хариуцлагаа мэдэж авч, гүйцэтгэн, хамтдаа зөвлөлдөж ажилласнаар энэхүү зорилгуудыг биелүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг.

Ахлагч М.Рассэлл Баллард Сүм дэх хороод, зөвлөлийн ач холбогдлын талаар ярихдаа “Гол зохион байгуулагч Бурхан маань зөвлөл, хороодын системийн зохион байгуулалтыг сүнслэгээр өдөөн дэмжсэн. Уг системийг сайн ойлгож, зөв зохистой хэрэглэснээр удирдагч бүрийн ачаа хөнгөрч, тэдний үйлчлэл бусдын дэмжлэг тусламжтайгаар олон нийтэд хүртээлтэй мөн үр нөлөөтэй байх болно” гэж хэлжээ. (“Counseling with Our Councils,” *Ensign*, 1994 оны 5-р сар, 24).

Гадасны аудитын хороо амжилттай ажиллахын тулд гишүүд нь хамтарч ажиллах хэрэгтэй. Хорооны дарга эсвэл аль нэг гишүүн нь бүх ажлыг ганцаараа хийх гэж зүтгэх ёсгүй. Ганцаараа ажилласнаар нэгдмэл гадасны аудитын хорооны болон хамтдаа зөвлөлдөн ажилласны ач тус, хүч, адислалыг хүртэж чадахгүй.

2. Зохион байгуулалт

Гадасны ерөнхийлөгч зөвлөхүүдийнхээ нэгийг гадасны аудитын хорооны даргаар мөн ариун сүмийн эрхийн бичигтэй, итгэлтэй хоёр Мелкизедек санваартныг уг хорооны гишүүнээр томилж, гадасны аудитын хороог бүрдүүлнэ. Энэ хоёр ах санхүүгийн талаар мэдлэгтэй байх нь ач тустай байдаг. Хорооны дарга нь чекэнд гарын үсэг зурах, төлбөрийг батлах болон санхүүгийн бүртгэл хөтлөх явцад оролцох ёсгүй. Хорооны гишүүд гадасны аудитор байх ёсгүй бөгөөд гадас эсвэл тойргийн санхүүгийн бүртгэлийг хөтлөх ёсгүй. (*Гарын авлага 1, 14.9.1-ийг үзнэ үү*.)

3. Үүргүүд

Гадасны аудитын хороо нь үндсэн дөрвөн үүрэгтэй. Үүнд:

1. Санхүүгийн аудитыг зохион байгуулж явуулна.
2. Гадасны аудиторудыг сургана.
3. Гадасны санхүүгийн бусад сургалтыг хариуцна.
4. Гадасны санхүүгийн эрсдлийг илрүүлж, дүгнэж, залруулахын тулд зөвлөлдөнө.

3.1 Санхүүгийн аудитыг зохион байгуулж явуулах

Гадасны аудитын хороо санхүүгийн аудитыг зохион байгуулж явуулахдаа дараах зүйлсийг хийнэ. Үүнд:

1. **Гадасны аудиторудыг аудитыг алдаа мадаггүй, нарийвчлан, цаг хугацаанд нь үйлдэхэд сургаж бэлтгэнэ.** Гадасны аудиторуд Сүмийн санхүүгийн дүрэм журам мөн аудитын асуулт бүрийн цаад утгыг ойлгож, аудит хийж буй нэгж бүрээс илэрсэн эрсдлүүдийг хэрхэн арилгахыг мэддэг байхын тулд сургалтад тогтмол хамрагддаг. (Энэ баримтын үргэлжлэлд буй “3.2 Гадасны аудиторудыг сургах” хэсгийг үзнэ үү).
2. **Хийгдэж буй аудитын чанарт хяналт тавина.** Гадасны аудитын хороо нь хийгдсэн аудит бүрийг алдаа мадаггүй, нарийвчлан хийгдсэн эсэхийг хянана. Шаардлагатай үед хороо нь аудитад засвар оруулахыг шаардах ёстой.
3. **Засах шаардлагатай зүйлсийн биелэлтийн чанарт хяналт тавина.** Гадасны аудитын хороо залруулах ажил бүрийг хянаж, энэ нь аудитаар илэрсэн алдааг засаж залруулахад, ялангуяа алдааны үндсэн шалтгааныг арилгахад хэр үр дүнтэй болохыг дүгнэнэ. Мөн хороо нь шаардлагатай үед тойрог, гадасны удирдагчидтай хамтран засаж залруулах ажлыг дахин хянаж ажиллана.

Жил бүр аудит хоёр удаа явагдана. Жилийн эцсийн аудит нь 7-р сарын 1-ээс 12-р сарын 31 хүртэлх гүйлгээнүүдийг хамардаг бөгөөд дараа жилийн 1-р сарын 15-нд эхэлж 3-р сарын 15-ны дотор илгээгдсэн байх ёстой. Оны дундуур явагддаг аудит нь 1-р сарын 1-ээс 6-р сарын 30-ны доторх гүйлгээнүүдийг хамардаг бөгөөд мөн оны 7-р сарын 15-нд эхэлж 9-р сарын 15-ны дотор илгээгдсэн байх ёстой.

Аудитуудыг интернэтээр Орон нутгийн нэгжийн санхүүгийн аудитын системийг (ОННСАС) ашиглан эсвэл ОННСАС-ээс хэвлэж гаргасан цаасан маягт ашиглан гүйцэтгэнэ.

Гадасны аудитын хорооны үүргийг гүйцэтгэхийн тулд аудит бүрд хороо гурван удаа хуралдаж мөн аудитын хорооны гишүүн бүр тусдаа зарим ажлыг хийх хэрэгтэй болдог. Хол замд аялахад хүндрэлтэй эсвэл зардал өндөр бол, бүсийн болон орон нутгийн удирдагчид эдгээр хурлыг видео хэлбэрээр эсвэл утсаар ярилцан хийж болно. Хэрэв утас, интернэт, эсвэл холбоо барих бусад ямар ч арга хэрэглэх боломжгүй байвал эдгээрээс өөр аргыг ашиглах шаардлагатай болж болно. (*Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* [2010], 17.2.2-ыг үзнэ үү). Гадасны аудитын хорооны хурал болгон дээр нууцлалыг хадгалахын чухлыг дурдаж байх хэрэгтэй.

Эхний хурал—Аудитын төлөвлөлт

Аудитыг нарийвчлан гүйцэтгэж, цагт нь илгээхийн тулд аудит эхлэхээс нэг юм уу хоёр долоо хоногийн өмнө гадасны аудитын хороо аудитыг төлөвлөх хурлыг хийнэ (1-р сарын 15 болон 7-р сарын 15-аас өмнө). Энэ хуралд гадасны аудитын хороо, гадасны аудиторуд, гадасны бичиг хэргийн ажилтан болон гадасны санхүү хариуцсан бичиг хэргийн ажилтан орно.

Хурлын хөтөлбөрт дараах хэлэлцэх асуудлууд орж болно. Үүнд:

- Аудиторудад үүрэг даалгавар өгнө.
- Аудиторудыг сургана.
- Аудитын асуултууд болон дагалдах заавруудыг хэлэлцэнэ. Аудитын асуултуудыг үр

дүнтэй давтахын тулд ОННСАС-ийн Аудитын дадлага хэсгийг ашигла.

- ОННСАС-ийн шинэчлэлтийн мэдэгдлүүдийг үзсэнээр системийн хэрэглээ болон чадварын өөрчлөлтийг мэдэж болно.
- Энэ удаагийн аудитаар илүү анхаарал тавих шаардлагатай эрсдэлтэй зүйл эсвэл сул талыг олж болохын тулд өмнөх аудитыг эргэж үз.
- Аудитаар илэрсэн алдаа дахин давтагдсан тохиолдлуудыг эргэн үзээд, өмнөх залруулах ажил үр дүнтэй байсан эсэхийг олж мэдэхэд ямар нэмэлт шалгалт хэрэгтэй болохыг ярилц.
- Аудитын нэг ч зөрчил илэрч байгаагүй нэгжүүдийг шалгаж дүгнэ. Аудитыг нарийвчлан хийж байгаа нөхцөлд нэг ч зөрчил илрэхгүй байх нь ховор байдаг.
- Бишопын зөвлөлд өөрчлөлт орох, шинэ бичиг хэргийн ажилтантай болох зэрэг удирдлагын өөрчлөлтийг аудиторруудад мэдэгд. Удирдлага өөрчлөгдөх нь аудиторруудад зарим нэг гүйлгээг сайн хянах сэдэл өгч болох юм.
- Аудиторруудын шалгалтаа хийх аргачлалд өөрчлөлт оруулж болохуйц гадасны дүрэм журмыг эсвэл гадасны аудитын хорооны өмнөх шийдвэрүүдийг ярилц.

Хоёр дахь хурал—Аудитын дүгнэлт

Гадасны аудитын хороо аудитын төгсгөлд нэгжийн удирдагчийг гарын үсэг зурсны дараа, гадасны аудитын хорооны даргыг гарын үсэг зурахаас өмнө аудитын дүгнэлтийн хурлыг хийнэ. Энэ хурал нь жилийн эцсийн аудитын хувьд 3-р сард, хагас жилийн аудитын хувьд 9-р сард болдог. Жилийн эцсийн аудитыг 2-р сарын эцэст, хагас жилийн аудитыг 8-р сарын эцэст дуусгаснаар гадасны аудитын хороо аудитыг хянаж илгээх хүртэл 15 хоног үлддэг. Аудит дээр гадасны аудитор болон нэгжийн удирдагч гарын үсэг зурснаар үүнийг *дуусгавар болсон* гэж үзнэ. Тойргийн аудит дээр гадасны ерөнхийлөгч гарын үсэг зурсны дараа энэ нь *илгээгддэг*. Гадасны аудит дээр гадасны аудитын хорооны даргыг гарын үсэг зурсны дараа энэ нь *илгээгддэг*.

Аудитыг хянах хуралд гадасны аудитын хорооны гишүүд, гадасны аудиторрууд, гадасны бичиг хэргийн ажилтан, мөн гадасны санхүү хариуцсан бичиг хэргийн ажилтан оролцоно. Энэхүү хурал нь аудитын үр дүнг хянаж, аудитаар илэрсэн алдаа бүрийн талаар хамтдаа зөвлөлдөх зорилготой юм. Гадасны аудитын хороо нь залруулах ажил бүр хангалттай явагдсан эсэхийг үнэлж, шаардлагатай бол залруулах ажлыг хэрхэн сайжруулах талаар зөвлөгөө өгдөг. Хэрэв залруулах ажил нь сул эсвэл асуудлын үндсэн шалтгааныг залруулахгүй байвал аудитын хорооны дарга эсвэл түүний томилсон хорооны гишүүн нэгжийн удирдагчаас үүнийг шинэчлэхийг шаардах ёстой. Энэ бол эрсдлийг илрүүлж залруулах хорооны үүргийн чухал хэсэг юм.

Аудитаар илэрсэн алдаа болон эдгээрийг залруулах ажлыг хянахдаа гадасны аудитын хорооны гишүүд хамтдаа хэлэлцэж, санхүүгийн ямар сургалтууд хэрэгцээтэй болох, нэмэлт сургалт хэнд ашиг тустай байж болох, мөн хэн энэ сургалтыг зохион байгуулах зэргийг шийддэг.

Аудитын хорооны дарга аудит дээр гарын үсэг зурснаар өөрөө төдийгүй хорооных нь гишүүд нэгжийн төлөвлөсөн залруулах ажлуудтай танилцаж, зөвшөөрч байгаагаа баталж байгаа бөгөөд мөн залруулах ажлуудыг цагт тухайд нь хийж гүйцэтгэн тайлагнасан байхыг шалгана гэсэн үг юм.

Гурав дахь хурал—Аудитыг хаах ба үнэлэх

Гадасны аудитын хороо аудитыг хаах болон үнэлгээ өгөх хурлыг жилийн эцсийн аудитын хувьд 4-р сард, хагас жилийн аудитын хувьд 10-р сард хийдэг. Энэхүү хурлын зорилго нь аудитын чанарыг хянан сайжруулж, санхүүгийн эрсдлүүдийг үнэлэн, залруулахад оршино. Энэ хуралд зөвхөн гадасны аудитын хорооны дарга, гишүүд оролцоно. Энэ үеэр гадасны аудитын үйл явц, санхүүгийн эрсдлийн талаар тодорхой ярилцдаг. (Энэ баримтын төгсгөлд буй “3.4 Гадасны санхүүгийн эрсдлүүдийг илрүүлж, дүгнэж, залруулахын тулд зөвлөлдөх” хэсгийг харна уу.)

Хурлын хөтөлбөрт дараах хэлэлцэх асуудлууд орж болно. Үүнд:

- Аудитыг хянах хурлаас өгсөн үүрэг даалгавруудыг хянаж, биелэлтийг шалга.
- Залруулах ажлууд гүйцэд хийгдсэн эсэхийг тодорхойл.
- Хэрвээ залруулах ажил нь аудитаар илэрсэн зөрчлийг арилгахад үр дүн муутай санагдвал өөр шийдлийг ярилцаж, ажил даалгах нь зүйтэй.
- Аудитын чанарыг хянаж үзээд, гадасны аудитор, нэгжийн удирдлага, бичиг хэргийн ажилтнуудад ямар нэмэлт сургалт хэрэгтэйг тодорхойл.
- Дараагийн аудитад зориулан хүмүүс, даалгавар, үйл явцыг өөрчлөх шаардлагатай бол үүнийг ярилцаж, бичиж тэмдэглэ.
- Эрсдлүүдийг үнэл—тэр тусмаа Сүмийн хөрөнгийг шамшигдуулах эрсдлийг үнэлээд, энэхүү эрсдлийг хэрхэн бууруулж болохыг тодорхойл.

Гадасны аудитын хорооны дарга аудитаар илэрсэн зөрчил хангалттай залруулагдсан гэж үзвэл үүнийг ОННСАС дээр залруулагдсан гэж тэмдэглэдэг.

3.2 Гадасны аудиторуудыг сургах

Гадасны аудитын хороо гадасны аудиторуудыг тогтмол сургаж, дараах зүйлсийг ойлгуулахад анхаарна. Үүнд:

1. Аудитын зорилго болон явц
2. Сүмийн санхүүгийн дүрэм журам
3. Гадасны аудиторын үүрэг болон аудит бүрийг хайраар мөн Ариун Сүнсний удирдамжаар явуулах үүрэг хариуцлага
4. Аудитын асуулт бүрийн илрүүлэх ёстой эрсдлүүд
5. Орон нутгийн нэгжийн санхүүгийн аудитын системийг (ОННСАС) хэрхэн ашиглах

Дараах сэдвүүдээр сургалт зохион байгуулж болно. Үүнд:

- Сүмийн санхүүгийн аудитын зорилго
 - Аудитын үеэр Сүнсийг хэрхэн таньж, дагах
 - Аудитын асуултын цаана буй зарчим бүр Сүмийн хөрөнгө болон удирдагчдыг хэрхэн хамгаалдаг талаар
 - Аудит хийх явцад дараах зүйлсийг хийх нь яагаад чухал вэ?
 - Аудитын асуулт бүрийг яг бичсэн байдлаар нь асуу.
 - Заавар бүрийг хянамгай уншиж дага.
 - “Бодлого хяналт болон эрсдлийн үнэлгээ” хэсэг дэх бүх нэмэлт асуултыг тавь.
- Нэмэлт асуултууд нь аудитын асуултын дараах зааварчилгаанд байдаг. Аудитын үеэр нэмэлт асуултуудыг ашиглан аудитор тодорхой эрсдлүүдийг илрүүлдэг.

Асуултуудыг өөрчлөн тавих юм уу заавруудыг үл ойшоосноор буруу хариулт авч, аудит үр дүн муутай болдог.

- “Санхүү” ба “Сүмийн халамжийг зохицуулах нь,” *Гарын авлага 1*-ийн 14 ба 5-р бүлгүүд
- Аудитыг хэрхэн чанартай явуулах мөн чанартай явуулсан аудит яагаад ихэвчлэн зөрчил илрүүлдэг талаар
- Аудитаар илэрсэн зөрчлүүд хэрхэн сурах боломжийг олгодог; яагаад аудитаар зөрчил илрэхээс айхын оронд үүнээс суралцах хэрэгтэй тухай мөн аудитууд хийгдсэнээр нэгжийн удирдлага, бичиг хэргийн ажилтнуудыг хэрхэн хүчирхэгжүүлж, тэдэнд сайжрах боломжийг олгож болох талаар
- Аудитын “Бодлогын хяналт ба эрсдлийн үнэлгээ” хэсгийн зорилго болон эрсдлийн үнэлгээний асуултууд аудиторын шалгалтыг хэрхэн чиглүүлдэг тухай
- Залруулах арга хэмжээг үр дүнтэй болгох зүйлс
- ОННСАС-ын Аудитын дадлага хэсгийг хэрхэн ашиглах тухай

Гадасны аудиторуудыг сургахад гадасны аудитын хороо голчлон ажиллана. Хорооноос тэднийг мөн бие даан судлахыг зөвлөдөг. LDS.org дээрх Тусламжийн төвд Сүмийн санхүү болон аудиттай холбоотой олон нийтлэл байдаг. ОННСАС дээр аудитын дадлага хийх нь хувиараа суралцах сайн арга юм.

3.3 Гадасны санхүүгийн бусад сургалтыг хариуцах

Гадасны ерөнхийлөгч нэгжийн удирдлагууд болон бичиг хэргийн ажилтнууд санхүүгийн холбогдолтой үүрэг хариуцлагаа мэдэж авч, Сүмийн санхүүгийн дүрэм журмыг дагадаг байхад анхаарна. (*Гарын авлага 1, 14.2.1-ийг үзнэ үү*).

Гадасны ерөнхийлөгчид энэ хариуцлагаа биелүүлэхэд нь туслахын тулд гадасны аудитын хороо аудитын үр дүн, аудиторуудын ажиглалт, гадасны санхүүгийн өмнөх сургалтын үр дүнгийн талаарх хорооны гишүүдийн өөрсдийн дүгнэлт дээр үндэслэн нэмэлт сургалт шаардлагатай эсэхийг тодорхойлно. Гадасны аудитын хороо гадасны ерөнхийлөгчийн зөвлөлд санхүүгийн сургалтын агуулга, хэзээ явагдах, хэн авах болон сургалт явуулах хамгийн тохиромжтой хүмүүс зэрэг мэдээллийг санал болгоно. Жишээлбэл, бишопт зориулсан санхүүгийн сургалтыг гадасны зөвлөлийн гишүүн хийвэл илүү үр дүнтэй байж болох юм.

Санхүүгийн сургалтыг гадасны ерөнхийлөгчийн удирдлаган дор дараах хүмүүс явуулна. Үүнд:

- Гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүд
- Гадасны бичиг хэргийн ажилтнууд
- Бүсийн туслах аудитор
- Мөн гадасны ерөнхийлөгчийн томилсон, шаардлага хангахуйц бусад хүн

3.4 Гадасны санхүүгийн эрсдлүүдийг илрүүлж, дүгнэж, залруулахын тулд зөвлөлдөх

Гадасны аудитын хорооны гишүүд гадасны санхүүгийн явц хэрхэн явагдаж байгааг болон Сүмийн санхүүгийн дүрэм журмуудын талаарх ойлголтоо сайжруулснаар хамтдаа үр дүнтэй зөвлөлдөхөд бэлтгэдэг. Сүмийн гарын авлагууд болон LDS.org дээрх Тусламжийн төвийн Бүртгэлийг хадгалах гэсэн хуудасны санхүүгийн хэсгийг хувиараа уншиж судалснаар бэлтгэж болно. Түүнчлэн Орон нутгийн нэгжийн санхүү болон аудитын системд (ОННСБАС) бүртгэгдсэн дуусгавар болсон аудитыг анхааралтай нягтлан үзэж мөн аудитын түүхэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өөрсдийгөө бэлдэж болно.

Гадасны аудитын хороо хамтдаа цуглан, гадасны санхүүгийн эрсдлүүдийг илрүүлж болохын тулд залбиралтайгаар ажиллан, эдгээр эрсдлийг залруулах сүнслэгээр өдөөгдсөн арга хэмжээг хамтдаа зөвлөлдөн тодорхойлдог. Эрсдлийн шинжилгээ нь ямар муу зүйлс тохиолдож болох болон энэ нь тохиолдох магадлал хэр өндөр байгааг тодорхойлдог үйл явц юм. Үүнд ямар нэг муу зүйлс болсон байх гэсэн таамаглал орж болно.

Сүмийн санхүүгийн эрсдлийн шинжилгээг хийхдээ дараах зүйлсийг голчлон асуудаг.

Тухайлбал:

Чухам юу буруугаар эргэж болох вэ?

Яагаад энэ нь буруугаар эргэж болзошгүй вэ?

Бид үүнээс сэрэмжлэхийн тулд юу хийж чадах вэ?

Гадасны аудитын хороо ядахнаа санхүүгийн эрсдлийн дараах шинж тэмдгүүд байгаа эсэхийг авч хэлэлцвэл зохино. Тухайлбал:

- Удирдагчид санаатай болон санамсаргүйгээр өөрсдийгөө хувийн зорилгоор сүмийн өмч хөрөнгийг шамшигдуулахад уруу татагдсан эсвэл ингэсэн гэж хардуулах нөхцөл байдалд оруулсан баримт байгаа эсэхийг авч үзнэ. Байж болох баримтууд нь:

- Нэгжийн удирдагчид юм уу түүний эхнэрт, эсвэл бусад удирдагч болон тэдний эхнэрт олон удаа мөнгө шилжүүлсэн байх
- Харгалзах баримтгүй олон удаа төлбөр хийсэн байх
- Өргөлүүдийг задалж, тушаахдаа үргэлж хамтрах зарчмыг баримтлаагүй байх
- Мөнгөө удааж байж банкинд тушаах
- Гадасны ерөнхийлөгч бишопуудтай хамт Нэгжийн санхүүгийн тайланг тогтмол болон үр дүнтэй хянахгүй байх
- Нэгжийн удирдагчид эсвэл бичиг хэргийн ажилтнууд нэгжийн санхүүгийн тайланг сар бүр хянахгүй байх
- Мацгийн өргөлийн ердийн бус төлөлтүүд эсвэл их хэмжээний мацгийн өргөл өргөсөн байх
- Аудитаар илэрсэн олон тооны зөрчилтэй байх
- Аудитын зөрчлүүдийг давтах
- Аудитын зөрчил удаан хугацаагаар илрээгүй байх
- Нэгжийн удирдлагууд аудитаар илэрсэн зөрчлийг ойлгохгүй эсвэл хэрхэн залруулахаа мэдэхгүй байх
- Сүмийн хөрөнгө болон санхүүгийн бүртгэлүүд ил задгай байх

Гадасны аудитын хороо гадасны гишүүдэд болон санваарын удирдагчдад тулгарсан санхүүгийн бэрхшээл, удирдагчдын туршлага ба мэдлэгийн түвшин, тухайн бүс нутгийн ёс заншил, банкны байршил, Сүмийн өмч хөрөнгө болон барилгын хамгаалалтын байдал зэрэг бусад эрсдлийг тооцон үзэж болно.

Санхүүгийн эрсдлүүдийг дараах арга замаар бууруулж болно. Үүнд:

- Аудитыг илүү нарийвчлан, алдаа мадаггүй, цаг тухайд нь хийснээр чанарыг сайжруулах

- Гадасны аудитын хорооны олж мэдсэн санхүүтэй холбоотой асуудлууд болон гарсан шалтгаануудыг тодорхой тайлбарлахад нь аудиторуудад туслах
- Нэгжийн удирдлагуудад алдааг давтахаас сэргийлж, асуудлын голыг залруулах төлөвлөгөө гаргахад туслах
- Сүмийн халамжийн зарчмуудыг зөв зааж, мөрдөж байгаа эсэхийг нь хянана (“Сүмийн халамжийн хөтөлбөрийг зохион байгуулах нь,” *Гарын авлага 1*, 5-р бүлгийг үзнэ үү).

Аудитын асуултууд нь бодож үзвэл зохих олон эрсдлийг илрүүлдэг. Тиймээс аудитын үр дүн болон тайлан нь гадасны аудитын хороонд эрсдлийн талаарх чухал мэдээлэл болно.

4. Хариуцлага

Гадасны аудитын хороо нь гадасны ерөнхийлөгчийн шууд удирдлаган дор ажиллана. Гадасны аудитын хорооны дарга нь хорооны үйл ажиллагааны талаар тогтмол тайлагнана. Түүний тайланд дараах зүйлс орж болно. Үүнд:

- Аудитын явцын мэдээлэл, аудитаас ажигласан зүйлс, аудитаар илэрсэн зөрчлүүдийн тойм болон уг алдаануудыг хэрхэн залруулсан зэрэг аудиттай холбогдолтой мэдээллүүд
- Сүмийн хөрөнгийг зүй бусаар зарцуулсан зэргийг багтаасан санхүүгийн эрсдлүүд
- Сургалт, ажиглалт, аудит болон бусад аргаар дамжуулан эрсдлүүдийг хэрхэн залруулж байгаа эсэх
- Явагдаж байгаа болон явагдах шаардлагатай сургалтууд
- Гадасны аудитын хороонд болон гадасны аудитороор нэмж хүн дуудах шаардлага

Ерөнхийлөгч Марион Ж.Ромни “Ах нар аа, эргэн ирж тайлагнах нь итгэлтэй бөгөөд ухаантай зарцын сүүлчийн үйлдэл байдгийг санаарай” гэж заасан. (“Welfare Services: The Savior’s Program,” *Ensign*, 1980 оны 11-р сар, 93).

5. Дүгнэлт

Бүрэн зохион байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулж буй гадасны аудитын хороо нь Сүмийн хөрөнгийг зөв ашиглаж, хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд гэгээнтнүүдэд адислалыг авчирдаг билээ. Гадас болон тойргийн аудитын зорилгыг *Гарын авлага 1* дээр “Мөн аравны нэг болон бусад хандив зохих ёсоор бүртгэгдэж,

Сүмийн санг зохих дүрэм журмын дагуу захиран зарцуулж, хамгаалж мөн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бүрэн бүтэн байхад анхаарч ажиллана” (14.9.3) гэж тодорхой тайлбарласан байдаг. Гадасны аудитын хорооны гишүүд үүргээ бүрэн биелүүлснээр Сүмийн ариун хөрөнгийг хамгаалж, үүнийг захиран зарцуулдаг хүмүүсийг хүчирхэгжүүлдэг.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ